

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/157/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Ховд хот 2026 он</p>	<p>Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг:tsetsegsurena@audit.gov.mn Цахим актив аудит ХХК -ын Аудитор: Д.Балжинням Утас:70432545 Цахим хаяг: Damiranbaljinnyam573@gmail.com</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	12
3.1. Албан шаардлага	12
3.2 Зөвлөмж	13
4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14
5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ	15

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг
Утас/Факс: (976)-7043-3061
Email: khovd@audit.gov.mn

2026.08.25 № 204
танай _____ -ны № _____ -т

МАНХАН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ
ЭМЧ Ж.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар букуу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.7, 14 дүгээр зүйлийн 14.4, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтууд, Монгол улсын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтад заасан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаартай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Эм боох бараа материалын он дамжсан үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй 19.6 сая төгрөг
- Тайлант онд тооцож олгосон цалингаас илүү дүнгээр нийгмийн даатгалд тайлагнасан 6.0 сая төгрөг
- Тайлант онд ажилтнуудад олгосон цалин хөлс, урамшууллыг анхан шатны баримттай тулган шалгахад улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон 25.9 сая төгрөг,

8426050481

Асуудлыг онцолсон хэсэг

Тус Эрүүл мэндийн төв тайлант онд Эрүүл мэндийн даатгалын хэлтэстэй байгуулсан гэрээний дагуу 7561 хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.

Эрүүл мэндийн даатгалын сангаас иргэдэд үзүүлсэн эмнэлгийн тусламж үйлчилгээний 150.4 сая төгрөгийн санхүүжилтийн авлага бүртгэж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд урсгал зардлаас 26.0 сая төгрөгийн, харьяа дээд шатны байгууллагын хөрөнгө оруулалт болон хандив тусламжаар 35.8 сая төгрөг, нийт 61.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 215.6 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авч данс бүртгэлд тусгасан байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд 7 зорилго 10 хөтөлбөр, 25 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлээр 95 хувиар биелэлтийг хүргүүлсэн бөгөөд сумын Засаг даргаас 82.8 хувиар дүгнэж, Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ худалдан авах гэрээг аймгийн Эрүүл мэндийн даатгалын газраас 85 хувиар тус тус дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>420,563,010.15</u>	<u>395,570,651.43</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.17	52,364,558.63
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	0.17	52,364,558.63
3121	Төгрөг	0.17	52,364,558.63
31211	Төрийн сангийн харилцах	0.17	52,364,558.63
33	АВЛАГА	274,335,864.98	152,254,651.22
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	533,195.87	320,006.95
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	273,802,669.11	150,367,694.27
335	Бусад авлага	-	1,566,950.00
3351	Байгууллагаас авах авлага	-	1,566,950.00
35	БАРАА МАТЕРИАЛ	146,227,145.00	190,951,441.58
351	Түүхий эд материал	81,107,388.40	91,030,879.95
35130	Эм боох материал	81,107,388.40	91,030,879.95
354	Хангамжийн материал	65,119,756.60	99,920,561.63
35410	Бичиг хэргийн материал	364,000.00	2,167,500.00
35420	Аж ахуйн материал	8,759,608.00	23,543,126.03
35450	Барилгын засварын материал	-	31,500.00
35460	Хүнсний материал	1,483,747.50	2,160,034.50
35470	Бусад хангамжийн материал	54,512,401.10	72,018,401.10
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,014,110,473.11</u>	<u>966,226,970.71</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,014,110,473.11	966,226,970.71
392	Биет хөрөнгө	994,316,073.11	946,432,570.71
39201	Барилга, байгууламж, орон сууц	665,715,019.00	665,715,019.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(105,918,763.49)	(126,591,781.61)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	254,980,586.47	275,966,586.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(48,653,984.01)	(74,871,787.22)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	316,553,412.82	319,613,826.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(118,722,888.68)	(154,342,001.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	53,863,721.99	65,816,361.99
39208	Хуримтлагдсан элэгдэл	(23,501,030.99)	(24,873,651.95)
393	Биет бус хөрөнгө	19,794,400.00	19,794,400.00
39301	Програм хангамж	350,000.00	350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(350,000.00)	(350,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	19,794,400.00	19,794,400.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,434,673,483.26</u>	<u>1,361,797,622.14</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>17,818,687.09</u>	<u>45,001.60</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	17,818,687.09	45,001.60
413	Өглөг	17,818,687.09	45,001.60
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	13,683,647.10	45,001.60
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,416,854,796.17</u>	<u>1,361,752,620.54</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,416,854,796.17	1,361,752,620.54
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	634,389,543.09	634,389,543.09

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

51101	Өмч: - төрийн	634,389,543.09	634,389,543.09
512	Хуримтлагдсан үр дүн	776,998,151.75	721,895,976.12
51210	Өмнөх үеийн үр дүн	776,998,151.75	776,998,151.75
51220	Тайлант үеийн үр дүн	-	(55,102,175.63)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,467,101.33	5,467,101.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,434,673,483.26</u>	<u>1,361,797,622.14</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,778,609,808.68	1,461,339,021.13
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	443,606,528.37	170,558,607.53
120	Нийтлэг татварын бус орлого	443,606,528.37	170,558,607.53
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	443,606,528.37	170,558,607.53
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	129,023,726.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	443,606,528.37	41,534,881.53
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө		35,784,100.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал		5,750,781.53
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,335,003,280.31	1,290,780,413.60
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,563,200.00	63,717,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,563,200.00	63,717,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,274,440,080.31	1,227,063,313.60
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,274,440,080.31	1,227,063,313.60
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,235,041,486.29	1,516,441,196.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,041,486.29	1,516,441,196.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,235,041,486.29	1,397,921,600.89
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	789,151,891.00	919,227,767.80
210101	Үндсэн цалин	466,314,554.00	486,997,972.08
210102	Нэмэгдэл	230,814,297.00	285,187,798.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,640,000.00	57,830,000.00
210104	Урамшуулал	53,383,040.00	89,211,997.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,718,438.14	118,003,250.98
210201	Тэтгэврийн даатгал	69,029,694.01	81,513,355.42
210202	Тэтгэмжийн даатгал	7,796,681.83	9,315,727.52
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,499,899.09	5,989,058.60
210204	Ажилгүйдлийн даатгал	3,600,004.40	4,216,839.85
210205	Эрүүл мэндийн даатгал	14,792,158.81	16,968,269.59
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,553,500.00	64,561,775.98

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	3,863,557.24	5,465,225.98
210302	Түлш, халаалт	53,650,900.00	58,346,550.00
210303	Цэвэр, бохир ус	1,039,042.76	750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	59,450,308.93	50,989,919.58
210401	Бичиг хэрэг	7,448,500.00	10,093,305.00
210402	Тээвэр, шатахуун	23,507,440.00	22,848,625.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,597,600.00	3,183,239.58
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	518,000.00	1,147,500.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	10,460,468.30	13,717,250.00
2105	Нормативт зардал	118,032,638.79	97,666,733.15
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	107,346,582.29	88,462,225.15
210502	Хоол, хүнс	10,686,056.50	9,204,508.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,909,140.00	25,357,850.00
210604	Урсгал засвар	6,760,140.00	25,357,850.00
2107	Томилолт, зочны зардал	2,298,000.00	2,672,000.00
210702	Дотоод албан томилолт	2,298,000.00	2,672,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,562,705.00	8,367,301.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,416,280.00	6,630,781.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	444,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,500.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	28,000.00	66,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	214,000.00	495,580.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,364,864.43	111,075,002.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	11,670,700.00	1,366,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	82,694,164.43	109,708,602.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	118,519,595.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	116,194,621.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	56,672,621.85
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	59,022,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,324,974.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,324,974.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>543,568,322.39</u>	<u>(55,102,175.63)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>543,568,322.39</u>	<u>(55,102,175.63)</u>

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(Төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>1,081,507,932.20</u>	<u>1,543,239,114.44</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	129,023,726.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	129,023,726.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	129,023,726.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	129,023,726.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,081,507,932.20	1,414,215,388.44
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	60,563,200.00	63,717,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,563,200.00	63,717,100.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	1,020,944,732.20	1,350,498,288.44
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,020,944,732.20	1,350,498,288.44
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>1,149,077,278.61</u>	<u>1,464,833,555.98</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,149,077,278.61	1,464,833,555.98
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,149,077,278.61	1,346,313,960.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	788,286,059.00	917,954,354.02
210101	Үндсэн цалин	375,975,323.00	411,136,164.81
210102	Нэмэгдэл	323,527,662.00	343,305,527.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	38,620,000.00	79,076,681.00
210104	Урамшуулал	50,163,074.00	84,435,980.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	99,781,139.01	117,917,831.83
210201	Тэтгэврийн даатгал	68,690,040.54	80,481,514.85
210202	Тэтгэмжийн даатгал	7,884,277.15	9,363,380.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,242,780.36	4,779,611.76
210204	Ажилгүйдлийн даатгал	3,825,517.93	4,656,309.14
210205	Эрүүл мэндийн даатгал	15,138,523.03	18,637,015.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	58,805,100.00	59,868,025.98
210301	Гэрэл, цахилгаан	3,700,000.00	5,465,225.98
210302	Түлш, халаалт	53,650,900.00	53,652,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,454,200.00	750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	38,602,639.00	64,529,209.08
210401	Бичиг хэрэг	5,453,799.00	11,952,500.00
210402	Тээвэр, шатахуун	23,432,040.00	27,716,274.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,597,600.00	3,183,239.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,770,400.00	6,999,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,348,800.00	14,677,295.00
2105	Нормативт зардал	97,627,396.60	128,198,837.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	82,437,596.60	110,202,237.20

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210502	Хоол, хүнс	11,684,800.00	9,717,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,505,000.00	8,279,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	43,143,990.00	42,241,951.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	29,885,100.00	10,963,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	4,279,200.00	2,534,500.00
210604	Урсгал засвар	8,979,690.00	28,743,951.00
2107	Томилолт, зочны зардал	2,298,000.00	2,385,000.00
210702	Дотоод албан томилолт	2,298,000.00	2,385,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,421,705.00	9,123,151.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,955,280.00	6,822,781.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,925.00	419,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	53,500.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	28,000.00	66,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	214,000.00	495,580.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	320,000.00	588,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,111,250.00	4,095,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,111,250.00	4,095,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	118,519,595.87
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	116,194,621.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	56,672,621.85
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	59,022,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	500,000.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,324,974.02
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,324,974.02
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>(67,569,346.41)</u>	<u>78,405,558.46</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	26,041,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	26,041,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	26,041,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	26,041,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(26,041,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(67,569,346.41)	52,364,558.46
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	(67,569,346.24)	0.17
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.17	52,364,558.63

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(Төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	776,998,151.75	1,416,854,796.17
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	776,998,151.75	1,416,854,796.17
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(6,597,076.06)	(6,597,076.06)
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	770,401,075.69	1,410,257,720.11
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	770,401,075.69	1,410,257,720.11
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	770,401,075.69	1,410,257,720.11
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(55,102,175.63)	(55,102,175.63)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	634,389,543.09	5,467,101.33	715,298,900.06	1,355,155,544.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(Төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,825,247,000.00	1,488,549,581.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,825,247,000.00	1,462,508,581.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,685,130,400.00	1,346,313,960.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,064,641,000.00	917,954,354.02
210101	Үндсэн цалин	442,882,300.00	411,136,164.81
210102	Нэмэгдэл	439,758,700.00	343,305,527.72
210103	Унаа хоолны хөнгөлөлт	68,000,000.00	79,076,681.00
210104	Урамшуулал	114,000,000.00	84,435,980.49
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	132,763,800.00	117,917,831.83
210201	Тэтгэврийн даатгал	89,468,700.00	80,481,514.85
210202	Тэтгэмжийн даатгал	10,823,800.00	9,363,380.82
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,411,900.00	4,779,611.76
210204	Ажилгүйдлийн даатгал	5,411,900.00	4,656,309.14
210205	Эрүүл мэндийн даатгал	21,647,500.00	18,637,015.26
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	60,442,800.00	59,868,025.98
210301	Гэрэл, цахилгаан	5,310,000.00	5,465,225.98
210302	Түлш, халаалт	53,652,800.00	53,652,800.00
210303	Цэвэр, бохир ус	1,480,000.00	750,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	81,268,400.00	64,529,209.08
210401	Бичиг хэрэг	13,393,700.00	11,952,500.00
210402	Тээвэр, шатахуун	37,050,400.00	27,716,274.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,446,400.00	3,183,239.58
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	12,627,600.00	6,999,900.00

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,750,300.00	14,677,295.00
2105	Нормативт зардал	187,883,800.00	128,198,837.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	159,517,400.00	110,202,237.20
210502	Хоол, хүнс	12,063,700.00	9,717,100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	16,302,700.00	8,279,500.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,441,900.00	42,241,951.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	47,917,600.00	10,963,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,000,000.00	2,534,500.00
210604	Урсгал засвар	45,524,300.00	28,743,951.00
2107	Томилолт, зочны зардал	4,860,300.00	2,385,000.00
210702	Дотоод албан томилолт	4,860,300.00	2,385,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,264,000.00	9,123,151.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,818,900.00	6,822,781.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	650,000.00	650,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	425,000.00	419,940.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	80,000.00	80,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	69,000.00	66,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	258,600.00	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	500,000.00	495,580.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,462,500.00	588,850.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,564,400.00	4,095,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	39,564,400.00	4,095,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	140,116,600.00	116,194,621.85
2132	Бусад урсгал шилжүүлэг	140,116,600.00	116,194,621.85
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	56,796,400.00	56,672,621.85
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	60,820,200.00	59,022,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	22,500,000.00	500,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	26,041,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	26,041,000.00
222001	Тоног төхөөрөмж	-	26,041,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,825,247,000.00	1,540,914,140.42
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	63,717,100.00	61,392,125.98
132001	Орон нутгийн төсвөөс	63,717,100.00	61,392,125.98
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,639,480,900.00	1,350,498,288.44
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	1,639,480,900.00	1,350,498,288.44
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	122,049,000.00	129,023,726.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	122,049,000.00	129,023,726.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		0.17
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		52,364,558.63

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 70,183.2 мянган төгрөгийн алдаа¹ зөрчил илэрч, санхүүгийн тайланд 18,653.5 мянган төгрөгийн алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Тайлант онд үүссэн авлагыг дутуу бүртгэсэн 1,566.9 мянган төгрөг
- Тооцоо нийлээгүйгээс өглөгийг илүү бүртгэсэн 337.0 мянган төгрөг
- Бараа материалын зарлагыг дутуу бүртгэсэн 16,749.6 мянган төгрөг

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 51,529.7 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрсэнд 19,627.5 мянган төгрөгийн 1 зөрчилд зөрчлийг арилгах албан шаардлага, 31,902.2 мянган төгрөгийн 2 зөрчлийг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж хүргүүлээ.

Аудитаар залруулагдаагүй материаллаг алдааны зөрчил нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 19,748.1 мянган төгрөгөөс их байгаа тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1. Албан шаардлага

3.1.1 Бараа материалын эм, эмнэлгийн хэрэгслийн данстай холбоотой

Илрүүлэлт: Эм боох бараа материалын он дамжсан үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүйтэй холбоотой 19,627.5 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.", 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ":, 12.2.1.жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4-т "комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Эм боох материалын бүртгэлээс тусгай зориулалтын материалыг салгаж бүртгэх, хэрэгцээнээс илүү нөөцлөхгүй байх, хугацаа дууссан эм, тариаг акталж устгах ажил зохион байгуулах, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах талаар албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

3.2.1. Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд тооцож олгосон хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос илүү дүнгээр нийгмийн даатгалд тайлагнасангай холбоотой 6,002.2 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй, иж бүрэн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг нийгмийн даатгалын байгууллагад залруулж тайлагнах

3.2.2 Цалин хөлс, нэмэгдэл урамшуулалтай холбоотой

Илрүүлэлт: Тайлант онд ажилтнуудад олгосон цалин хөлс, урамшууллыг анхан шатны баримттай тулган шалгахад улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосонтой холбоотой 25,900.0 мянган төгрөгийн зөрчил илэрлээ.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д "улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно" 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 2.2 дахь "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цалин хөлсний нэмэгдлийг засгийн газрын тогтоолын дагуу олгох

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 05 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Манхан сумын Эрүүл мэндийн төвийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл /мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс Залруулсан	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Тайлант онд үүссэн авлагыг дутуу бүртгэсэн	1	1,566.9			1	4,164.0	1
Тооцоо нийлээгүйгээс өглөгийг илүү бүртгэсэн	1	337.0			1	337.0	1	337.0
Бараа материалын зарлагыг дутуу бүртгэсэн	1	16,749.6	1	16,749.6			1	16,749.6
Нийт дүн	3	18,653.5	1	16,749.6	2	4,501.0	3	21,250.6

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл /мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Эм боох бараа материалын он дамжсан үлдэгдэл өндөр, бараа материалын ангилал буруу бүртгэсэн, хугацаа хэтэрсэн эм, эмнэлгийн хэрэгслийг акталж устгах арга хэмжээ аваагүй, тооллого тооцоо хийж актаар баталгаажуулаагүй,	1	19,627.5			1	19,627.5		
Тайлант онд тооцож олгосон цалингаас илүү дүнгээр нийгмийн даатгалд тайлагнасан	1	6,002.2					1	6,002.2
Тайлант онд ажилтнуудад олгосон цалин хөлс, урамшууллыг анхан шатны баримттай тулган шалгахад улирлын үр дүнгийн урамшуулалтай давхардуулан урамшуулал олгосон	1	25,900.0					1	25,900.0
Дүн	3	51,529.7	0	0	1	19,627.5	2	31,902.2

**5. ТӨСВИЙН ЗАХИРАГЧИЙН АНГИЛЛААР АУДИТАД ХАМРАГДСАН БАЙДАЛ БА
САНАЛ ДҮГНЭЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЛИЙН НЭГТГЭЛ**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		